

**ДААЛУУНЫ НААДГАЙД БАЙГАА ЖҮЖИГЛЭГ ШИНЖ ДААЛУУНЫ
НААДГАЙ ЖҮЖИГ БОЛОХ НЬ**

Л. Чулуунбаатар*

Монголчууд бол баялаг түүхт уламжлал, бахархам сайхан ёс заншилтай төдийгүй дорнын өндөр соёлыг бүтээн бий болгоход өөрийн хувь нэмрээ зохих ёсоор оруулсан, хүмүүн төрөлхтний оюун сэтгэлгээ, соёлын санд Монгол хэмээх давтагдашгүй өвөрмөц өнгийг дархлаан шингээж чадсан гайхамшигтай ард түмэн билээ.

Их эзэн Чингис хааны үеэс монголчуудад ёс горим, зан үйлийн талаар эмх цэгцтэй, нарийн чанд өв соёл үйлчилж байсан байна. Үүний нэгэн илрэл нь монголчуудын “Даалууны наадгай” юм. *“Даалууны наадгай нь орчлон ертөнцийн хувьсал, хорвоогийн өнгө аяс, амьдралын хэм хэмжээг уран яруу илэрхийлдгээрээ ард түмний билэг оюуны охь юм”* гэж судлаач Л.Чулуунбаатар (Sc.D дэд доктор) хэлжээ. Монголчууд даалуугаар наадахдаа нутаг нутгийнхаа аж ахуй, зан заншилын өвөрмөц онцлогоос хамаарч өөр өөрийн гэсэн өнгө аястай хэл хэллэгийг тусгасан олон хувилбартай байдаг байна. Үүнээс үүдэн даалууны наадгайг газар зүйн байрлалын үүднээс баруун зүгийн бүс, зүүн зүгийн бүс, төвийн бүс, говийн бүс, Хөвсгөл орчмын бүс хэмээн таван бүсэд хуваан ангилж болно.

Даалуу хэмээх энэ тоглоом хятад орноос монгол нутагт нэвтэрсэн бөгөөд хятад хэлний *dā liu* буюу “*их зургаа*”- *мо.б daluu* хэмээх үг бөгөөд энэ тоглоомын нэрээс гадна 12 нүхтэй модыг бас нэрлэдэг байна. Даалууны гуншинд өөрсдийн нутаг усны нэр эсвэл алдартай, даалуунд сайн, сайн муугаар нэрд гарсан хүн байх жишээтэй. Тэрчлэн эрүүл мэндийн, ахуй амьдралын зөвлөгөө ч байдаг юм. Монголчуудын тоглоом наадмын дотор даалуун наадгай онцгой байр эзэлдэг. Даалуугаар дан, давхар жаалах, гэр барих, нүх шахах зэрэг олон төрлийн хэлбэр маягаар тоглодог байна. Ингэж тоглохдоо аль алинд нь даалууны гуншин хэлэх бөгөөд энэ нь тоглоомыг хөгжөөдөг байна. Даалуун наадгайн хамгийн өндөр тоотой мод буюу даалуу нь зургаан хар, зургаан улаан нүднээс бүрдсэн байдаг нь тус тоглоомыг даалуу буюу “*их зургаа*” гэж нэрлэх үндэс болсон байна. Монголчууд даалууны нэрийг монголчилж нэрлэсэн байдаг боловч хятад нэрээр нь мөн адил нэрлэх нь элбэг тохиолддог.

Даалуу- их зургаа *da-* их, *liu-*зургаа

Үүлүү- тав зургаа, *wu-* тав,

Сийлүү-дөрөв зургаа, *si-*

Хуньд- улаан газар, *hong-*улаан, *di-*газар

Чанс- урт, өсөх ургах, *chang si-*дөрөв

Банд- *ban-*хагас, тал *di-*газар

* МУИС-ийн МХСС-ийн доктор, профессор

Ёоз- уо-нэг (эртний), zi-ы... гэх мэтчилэн нэрлэсэн байдаг.

Даалууны наадгай нь бүхэлдээ жүжиг юм. Театрт жүжиг хөшиг нээгдсэнээс эхэлдэг бол даалуун наадгайд тоглогчид суудалдаа сууснаас жүжиг эхэлдэг. Тайзны урлаг амьдралаас хол тасархай байж болохгүй харин ч бүүр хамгийн ойр, үнэн, амьд байх ёстой.

Даалуу тоглож буй хүмүүс үнэн амьд харьцаагаар харьцаж тоглодог. Даалуугаар наадаж буй тоглогчид тоглоомныхоо байр байдалд тааруулж тоглосноор маш олон дүр бүтээх шаардлагатай болно. Тухайлбал “*цай хураах*”-д олон цайтай хүн цайгүй өрөнд орсон хүнийг худалдаж аваад “*ноён*”-ы дүрийг, харин худалдагдсан хүн боолын дүрийг бүтээдэг. Ноёны дүрд тоглож буй хүн эрх дархаа ашиглан бүх цайг хурааж авахаар улайран тэмцэнэ. Үүний нэг илрэл бол боолдоо боол худалдаж авах билээ. Ингэснээр хожих магадлал улам нэмэгддэг. Өнөөгийн нийгэмд эрх мэдэл бүхий хүмүүс амьдралынхаа баталгааг бий болгохын тулд хүрээллээ өөрийн гэсэн хүмүүсээр үүсгэдэг. Хүмүүс тоглохдоо “*Дүрд орж*” үнэн амьдардаг. Тэрчлэн даалуучин хүн жүжигчний мэргэжлийн **гурван үүд** буюу хэл, бие, сэтгэлийн нэгдлийг эзэмшсэн байдаг.

Хэлэхүйн үйл буюу тайзны яриа: Монгол ардын аман зохиолын ихэнх төрөл зүйл нь шүлэглэсэн хэлбэрээр уламжлан ирсэний нэг жишээ нь даалууны гуншин болно.

Даалууны гуншин нь монгол аман шүлгийн нэг сонин хэлбэр юм. Даалууны гуншинд монгол шүлгийн тогтолцооны мөр, бадаг, холбоц зэрэг шинж чанарууд хадгалагдаж байна. Одоогийн байдлаар олдоод байгаа даалууны гуншин дотор хоёрхон шадтай хос уянгаас эхлээд хорин гурван мөр бүхий гуншин ч байна.

Мөр нь шүлгийн хамгийн бага нэгж юм. Харин хамгийн бага мөрөөс бүтсэн шүлэг нь хос уянга юм. Энэ хос уянгын мөрүүд даалууны гуншинд нилээдгүй тааралддаг.

Жишээ нь: Сийлүү нэртэй арав
Сэтгэл сайтай хүүхэн

Бадаг нь холбоцын нэгэн хэмнэлд захирагдсан тодорхой утга төгссөн хэд хэдэн шадын нийлбэрийг хэлдэг бол даалууны гуншинд мөн энэ хэлбэр байна.

Жишээ Ёгзолдоржийн хөдөөнөөс

Ёнзон хамбын гадаанаас

Цайны сүүний гуйлгачин

Цалам барьсан дээрэмчин

Хон хэрээний нүд

Хоёр нүдний дуран

Хойт хотын данжаад

Хоёр нүхтэй ёоз

Зогсоц нь яруу найргийн зохиолд айзмын хэмнэл, утгын хэмнэл хоёрын төрөл заагийг тодотгохын тулд хэрэглэгддэг бол даалууны гуншинд мөн л энэ зогсоц хэрэглэгдэж байна. Хэмнэлийн зогсоц буюу (*ритмический*). Зогсоцыг мөр хоорондын (*мет стиховые*), үг хоорондын (*цезура*), үе хоорондын (*лейма*), холбоос зогсоц (*инверсивные*) гэж хуваадаг. Даалууны гуншинг дуудахад үг хоорондын зогсоц их хэрэглэгдэж байна.

Жишээ нь: Амбан хааны яран нүүрт гэх мэт. Тэрчлэн даалууны гуншингийн үг хэллэгүүд нь монгол ардын аман наадгай буюу хэл зүгшрүүлэх үг, жороо үг зэргийн

нэгэн адилаар хурц тод үг хэллэгтэй байдаг нь хэл засах дасгал болохоос гадна, тухайн үед тоглогч сэтгэл хөдлөлөөрөө дамжуулан зохиож хэлдэг нь хурц тод сэтгэдэг болоход нөөлөөлдөг байсан нь дамжиггүй.

Сэтгэхүйн үйлдэл жүжигчний уран чадвар: Даалуучин хүний тоглолтын хамгийн чухал арга бол тоглолтоо нууж тоглох юм. Театрт хамгийн сайн *жүжигчин далд сууриа (второе план)* ил гаргалгүй нууж тоглодог бол даалуугаар наадахад ч мөн адил тоглогч далд сууриар тоглодог. Тоглолт эхэлснээс хойш сайн модтойгоо нууж муу модтой юм шиг жүжиглэх, тоглоом дуусах мөчид сайн модоо ил гаргаж хожих зэрэг нь жүжигчин жүжгийн явцад хайртай хүндээ хайргүй юм шиг байж далд сууриа нууж тоглохтой адил юм. Мөн даалуучин даалуугаа олон даалуун дунд сайн таньж ялгадаг байх, хэнд ямар мод очсоныг тогтоох гээд жүжигчин хүний хийх ёстой хамгийн чухал дасгал болох *анхаарлын дасгалыг* байнга хийдэг гэсэн үг болж байна. Мөн хэнд хэдэн цай байгаа, хэн хэн ямар ямар мод гартаа барьж байгааг санаж байх ёстой байдаг нь түүнд *ой тогтоолтын* дасгал болдог учраас даалуучид анхаарал ой тогтоолт сайтай, хурдан түргэн сэтгэдэг хүмүүс байдаг.

Хөдлөхүйн үйл буюу тайзны хөдөлгөөн: Даалуучин өөрт байгаа модныхоо намба төрхөнд тохируулан үйл хөдөлгөөн хийдэг нь монгол ардын бие биелгээтэй ихээхэн төсөөтэй байна. Биеийн үйлдлээрээ дамжуулан модныхоо эв хавыг гайхуулж өрсөлдөгчдөө мод болон үйлдлээрээ далайлган сүрдүүлж сэтгэл санааны дайралт хийдэг.

Тоглолтынхоо байдал, сэтгэлийн хөдлөлгөөн, хэлж буй гуншингаасаа хамаарч үйл хөдөлгөөн нь жижиг эсвэл далайцтай байна. Яг тухайн үеийнхээ сэтгэгдлээс хамаарч дахин давтагдашгүй сонин содон үйлдлүүдийг олон хийдэг нь бие биелгээтэй туйлын төсөөтэй.

ХАВСРАЛТ:

Даалууны гуншин нутаг нутагт хэрхэн хэлэгддэг талаар судалсан
судалгаа:

- 1- Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутгаас бичиж авсан тэмдэглэл.
- 2- Ховд аймгийн Дуут сум. Хөх бэлчир баг. Бөөрөг хавцлын бэлчир. Шурагийн Сүх.73 настай, эрэгтэй, Алтайн урианхайн Оорцог сум, Хорхон элхэн.
- 3- Дундговь аймаг Эрдэнэдалай сум Эрэнцэндорж
- 4- Ж.Бат-Ирээдүй, Ч.Арьяасүрэн, Монгол ёс заншлын их тайлбар толь, 326-329

- Даалуу 1 – Даа хамбан даалуу
Дахаа чирсэн хужаа
Давхар мосттой жаран ес
Дарга хүний унаа
Даа хээрийн намаржаа
Дааган морины арилжаа
Алагийн уруу зүлэг ширэгтэй
Алтан болон боронзон даалуу
- Даалуу 2 - Даа хундан даалуу
Дахаа чирсэн хөгшин хужаа
- Даалуу 3 - Алагийн нуруу зулгийн шил
Алтан пай гуранзан даалуу

Даалуу 4-

- А Хамбан эрээн даалуу
Хар мөрөнгийн жанжин
Энэ наадмын эзэн
Эрээн алаг даалуу

- Б Алгийн нуруу зулгийн шил

Үүлүү (Хуутуу) 1– Үүлэн цэнхэр мөрний хөшгөн дээр

Үүлэн гарч бороо орно
Үдэш болж нар жаргана
Үг сөрж хэрүүл гарна
Ху ноёны хурдан борлог
Хулгайд унадаг дэгжин борлог

Үүлүү 3– Лүн ордог замтай

Лүүжин тавьдаг ламтай

Улаан арав 1– Сийлүү араваар сэнгэнүүлэн

Сисчээрт суугаад гонгинуулна
Сэтгэл нь байвал чам дээрээ
Синлүү байвал вокзал дээр аваад очно

Улаан арав 2 – Сийлүү нэртэй арав

Сэтгэл сайтай хүүхэн

Сийлүү 3– Сэвээ жидийн ороомог (ороосон маягийн юм байна)

Сийлүү арав 4–

- А Сэмбэн нэртэй сийлуу
Бумбан нэртэй рашаан
Б Сэгэлзүүрийн бэгэлзүүр
Сэгэл Туулын бургас
Сэлээд бууны хугархай
Сэнж модны тайранхай
Сийчаа наачаа Дүнхэр даалуу
Сийлэн бөөрийн ягаан яатуу

Барзгар арав 1– Арсаг хааны дарсаг хаан

Амбан хааны тэмбүү нүүр

Хар 10 – Амбан хааны яран нүүрт

Хар арав хандгай буга

Ханд хүүхэн миний найз

Бажиг түжиг баваалай

Бадамхандын яран нүүрт

Хар арав модны найз

Хандгай буга уулын найз

Бажгар арав 3– Азай гүний бажай цоохор

Агсан гүүний жороо цоохор

Хэнтий аймгийн хээр цоохор

Хэрлэн голын бор цоохор

Хар арав 4–

- А Хар арав Хандын найз
Хандгай буга уулын найз

Ханд хуухэн миний найз
Б Арзай Бадрын чулуу
Далай Бадрын хөөс

Улаан найм 1 (*хуньт найм, чавганц найм*) -
Жар хүртлээ хүнтэй сууж
Хүүхэд гаргаагүй жартгар улаан самган
Хүрээ орж хүнтэй танилцаж
Хүүхэд гаргахаар явлаа

Тэмээ найм 2 – Тэмээ найм
Тэр эргэндээ устай

Улаан найм 3 – Хүнтэй ердөө суугаагүй
Хүүхэд ердөө гаргаагүй
Жаран жил сувайрсан
Жартгай улаан чавганц

Хуньд найм 4:

А Гунжин хуньдын дайлаадас
Гурван нуурын цалгиадас
Гуна гулгадаг
Гунж мөөрдөг
Дөрөө хангинадаг
Б Наян жил насалсан
Намбагар улаан чавганц

Шор долоо 2 – Гозон долоо гоохолзож
Говийн хүүхэн шоохолзоно

Шовх долоо 3- Гоожоо зангийн гоншигнуур
Голдоо нүхтэй дэншигнуур

Шор долоо 4:

А Гозон долоо шоохолзоно
Говийн хүүрэн шоохолзоно
Б Шорнойн уулын цэцэг
Шовхон хоолой Долгорсүрэн
Шоотон хоолой Думаажав
Шоорон Сандуй
Шуудай Чоймбол
Уургын Наваан
Улцан Хайдав

Цэцэг зургаа 1 – Тал хээрийн булуу
Атар газрын цэцэг
Тав байхад булуу нэг сайхан
Таргалуулж унахад морь нэг сайхан

Тавнаг зургаа 3- Таахай булуу тачигнана
Таван хуруу догшин

Тав нэг “цэцэг зургаа” 4-

А Таван булуу нэг ялуу

- Таргийн бүлүүр
Айргийн хутгуур
- Б Тавьж өгөхөд тав нэг сайхан
Таргалуулж унахад морь сайхан
Булуу тав нэг будантай
Буцаад татах нь манантай
- Ташуу зургаа 1 –** Чацга сайвар чонын гүйдэл
Чанасан будаа нохойн хоол
Чацуу нэртэй зөрүү зургаа
- Ташуу зургаа 2 –** Хаяа голын бургас
Ханан хээтэй чанс (*ганс байж магадгүй*)
- Чанс зургаа 3-** Чаагаа дээлийн мөнгөн товч
Захан дээрээ бөнжийнө
- Чанс зургаа 4:** Часаг сайвар чонын гүйдэл
Чанасан будаа нохойн хоол
Янаг хоолойн гуниг сэтгэл
Ясчин хятадын жирүү зургаа
- Оймс дөрөв 1 –** Бөгтөр дөрвөөр гүйдэлтэй
Дорнодын хурдан шарга
Бөөхэй хотын бөгсөөр сүнгэнэдэг дөрөв
- Оймс дөрөв 2 –** Бөхөөн дөрвөөр гүйдэлтэй
Бээжин хотын данжаад
- Бөхөөн дөрөв 3-** Оодон борын сүүл
Орос гутлын дах
- Бөхөөн 4-**
- А Өөхий бөөхий дөрөв
Өвчүү номин шаргал
Бөгжөө Сэнгийн хожуул
Бөхнөг түргэн гүйдэлтэй
Дорниун хурдан шарга
- Б Бөх нуман дөрөв
Бөөхий хотын данжаад
Бөх Лувсаншарав (*Булган аймагт нэртэй даалууч бөх
Лувсанишарав байсан гэнэ*)
- Банд дөрөв 1 –** Ван хүний үр
Сүүтэй гүүний унага
Вандан ширээ балбаж
Ваартай архи нь цалгиж
Багийн найз баярлаа юу
- Ванд буюу Вандан дөрөв 2 –** Ванд балаа булгийн дэнж
Вандан сөөхөө дөрөв
- Банд дөрөв 3 -** Вандан ширээ нь багадаа юу
Баартай архи нь цалгиа юу

Тэгш дөрвөн хүслэн
Амьд таван эрдэнэ

Ванд дөрөв 4:

- А Вандан суудал
Зандан ширээ
- Б Вандан хаадын сүгнэн хаад
Баавай ламын хүргэн хар
Ван хүний үр
Сүүт гүүний унага
Ванд нэртэй дөрөв.

Сохор хоёр 1 –

Уулын өндөр модонд нь
Хөхөө шувуу донгодно
Улцгар хоёр нүдэнд нь
Гунигийн нулимс бөмбөрнө

Ёоз буюу сохор хоёр нүд 2 –

Ёозыг мод дагадаггүй
Ёонзон хамбыг чөтгөр дагадаггүй

Ёоз 3 -

Шилийн голын ялаа
Шингэ дэрсний туулай
Хон хэрээний нүд
Хоёр нүхтэй ёоз

Ёоз4:

- А Ёгзолдоржийн хөдөөнөөс
Ёнзон хамбын гадаанаас
Цайны сүүний гуйлгачин
Цалам барьсан дээрэмчин
- Б Хон хэрээний нүд
Хоёр нүдний дуран
Хойт хотын данжаад

Жанли буюу дууддаг моднууд- завхай найм

Улаан ес 1 –

Улаан ес нь жидавхаа
Уландаа үстэй тангад

Улаан ес 2 –

Улаан есөн зулаг зээрд
Уландаа үстэй Тангад

Гавал ес 3-

Гавал дамар сэндэн хонх
Гайгүй хийсэн төмөр хонх

Гавал ес 4-

- А Толгой дээгүүр сэнгэдэг
Доржсэндэн гавал
- Б Улаан есөн жовдуухай
Уулаар явдаг галуухай
Уманд явдаг жараахай
Улсын сангийн Буханхүү

- Цагаан ес 1 –** Дэгээ цагаан ес
Дэгжин цагаан хүүхэн
Дэгээнд нь дээлээ
Дэгжинд нь нүүрээ маажуулуузай
- Цагаан ес 2 –** Дэгээ цагаан ес
Дэнжийн цагаан лам
Жингийн цагаан ат
- Дэгээ ес 3-** Дэгээн есөнд дээлээ уруулж
Дэгжин хүүхэнд бандаашаа тайлуулав
- Дэгээ ес 4-**
- А Эгээ зүгээр явахаар
Эгмийн цагаан дэгээ
Дэгээ есөнд
Дээлээ уруулж
Дэгжин хүүхэнд
Нүүрээ маажуул
- Б Цагаан дэгээ машин хутгуур
Царил хааны маажгий гуталт
- Муруй найм 1–** Муруй найм наян цаас
Мулгуй хүүхэн жаран цаас
- Муруй найм 2 –** Муруй хазгай гүйдэлтэй
Мундаа дороо цоорхой
- Муруй найм 3-** Сайн хэлвэл сариу найм
Сайрхаж хэлвэл муруй найм
Аргаа үүрсэн баргын авгай
Аралаа түүсэн Дарьгангын авгай
- Савар найм 4-**
- А Адуу малын үнэтэй
Аргай мундаг найм
Тэмээ малын үнэтэй
Тэнгэр харсан данжаад
- Б Сайн хэлбэл сарий найм
Муу хэлбэл муруй найм
Дахиад хэлбэл далиу найм
Давтаад хэлбэл тэмээ найм.
- Сарлаг долоо 1 –** Сарлагийн махан тогоо дүүрэн
Сандагийн хүүхэн өвөр дүүрэн
Сарлаг үхрийн санаа муу
Сармай дээлтийн хормой муу
Мал малын зах
Манай нэгдлийн сүрэг
Майжгий туруутай сарлаг
- Сарлаг долоо 2 –** Сарлагийн мах сав дүүрч
Сандагийн хүүхэн өвөр дүүрнэ

- Сарлаг үхрийн санаа муу
Саальтай дээлийн хормой муу
- Сарлаг долоо 3-** Долоон малын сарлаг
Догшин газрын савдаг
- Сарлаг долоо 4:**
- А Долоон уулын сарлаг
Догшин газрын савдаг
- Б Жадрын гүүрээр нутагтай
Жаран давхар баринтагтай
Жаварт даардаггүй Буханхүү
- Шанага долоо 2 –** Шанага авч
Цайгаа самар
- Шанага долоо 3-** Шандай голын эхэн дээр
Молом тойны охин хурал хурж байна
- Шанага долоо 4-**
- А Долоон бурхан шинжтэй
Долнуур авгайн шанага
- Б Гуян хүү долоо
Гурилын хүү шалсай (*зоог идээ гэсэн утгатай төвд үг бөгөөд
гурцлаар хийсэн тахилын нэр ажээ*)
Гутлын хүү шаахай
- Нохой зургаа 1–** Гөлгөн нохой гэмтэй шүү
Гөлмөө шууж мордоорой
Гөөгийн хүүхэн тэмбүүтэй шүү
Түүнд л битгий ойртоорой
- Нохой зургаа 3-** Гичий нохой гэлхэнцэг
Өөхтэй хавирга халханцаг
- Нохой зургаа 4**
- А Зуудаг нохойн зулзага
Зургаан нүхтэй даалуу
- Б Жингэр жингэр дуутай
Жинчин дагасан халтар жийг
- Чүү тав 1 –** Алан тавын далан тав
Аарцаг махны чичлүүр тав
Арван аймтын бамбуу тав
- Таван нүд 2 –** Алан тавын бэлэн тав
Аарцаг махны чичлүүр тав
- Чүү тав 3-** Чүмаа тавын налжирмаа
Шөнийн уртын хандармаа
Аавын хүүгийн хэрэглэ
Арван наймтын чичлүүр
- Чүү тав 4-** Чүтаа лүндэг баян зээрд

Чүү тавын ган тав
Чүтэл хоргойн мөнгөн цоолтуур

- Хүзүү найм 1 –** Хүзүү найм хүний найз
Хүүхэн Дулмаа миний найз
- Хар хүзүү найм 2 –** Хүзүү найм модны найз
Хүүхэн Дулам миний найз
- Дөнгө найм 3-** Дөнгөн жийжүү хотын банзал
Дөнгөж сурсан хужаагийн эрлийз
- Дөнгө найм 4-**
- А Эрлүү дөнгө
Эрийн найз
Эхнэр хүүхэд
Гэрийн найз
- Б Дөнгө биеийг чилээнэ
Дөрөө хөлийг чилээнэ

Майхан авахдаа – Майхан нэг нь наашаа
Майжгар хоёр нь цаашаа

Хожил авч цохдохдоо – Чи байтугай чийчаан
Та байтугай тарактор явдаггүй замаар
Амаа мэддэггүй агсам азаргатай
Хаа хүрч явна вэ
Дураа цааш нь
Духаа нааш нь

Бүхэл даалууны нэрийг энэ үүднээс судлан тайлбарлах гэвэл их цаг, хөдөлмөр шаардах тул энэ удаагийн илтгэлд гуравхан модны гуншингийн талаар авч үзэхээр шийдсэн болно.

Сохор хоёр нүд буюу ёоз:

Ёозыг мод дагадаггүй

Ёнзон хамбыг чөтгөр дагадаггүй хэмээн гуншинг дуудсан байна. Сохор хоёр нүд гэсэн нь сохор нүдээр юу ч харж, мэдэрч болохгүйн нэгэн адил ёозоор ямар ч модыг идэж, дарж болохгүй хамгийн бага ашиггүй мод гэсэн утгаар ингэж нэрлэсэн байна. Гэвч “*Аз байвал ёоз хүүгээр иднэ (цохино)*” хэмээх өвөрмөц хэлц монгол хэлэнд бий. Зарим тохиолдолд гэр барьж тоглоход улаан цагаанаар дагнан тоглож байгаа үед хоёр ёоз буюу хос ёоз бас ус ч гэж нэрлэдэг энэ модоор идэж гэр барих тохиолдол бий. Мөн жаран хардаа жаалах үед ийм боломж хааяа тохиолдохоос үүсч ийм хэллэг гарсан бололтой. Энэ нь одоо монгол хэлэнд хэвшээд утга шилжин азтай бол жаахан зүйлээр ч их хэргийг бүтээж болно гэсэн санаа илтгэдэг байна. Ёнзон хамбыг чөтгөр дагадаггүй хэмээсэн нь Ёнзон гэдэг бол yongs ‘dzin хэмээх төвд үг бөгөөд монголоор бол мэргэн багштан гэсэн утгатай байна. Хамба хэмээх нь mkhan ро хэмээх төвд үг бөгөөд монголоор сүм хийдийн хэргийг тэргүүлэн удирдах тушаалтныг хэлдэг байна. Тэгэхээр Мэргэн багш бөгөөд хамбын албыг хашиж байгаа лам хүн бол олон жил бурхны номонд суралцан эрдмийн өндөр зэрэгт хүрч, гэгээрлийн дээдийг олсон хүн байх тул эрдэм ухаан, энергийг төгс жолоодогч байх тул чөтгөр шулам буюу муу сөрөг энергийг

маш амархан даран сөнөөх чадалтай нэгэн байдаг тул ийнхүү чөтгөр дагадаггүй хэмээн хэлсэн хэрэг байна. Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутгаас 2010 онд мөн ХИС-ийн профессор, доктор Мөнгөнхүүгийн Ганболдын бичиж авсан ёозын гуншин дээрхээс өөр байна. Сохор хоёр хэмээн нэрлээд

Уулын өндөр модонд нь

Хөхөө шувуу донгодно

Улцгар хоёр нүдэнд нь

Гунигийн нулимс бөмбөрнө хэмээсэн байна. Хөхөө шувуу донгодсон хаврын сүүл, зуны эхэн сарын найртай сайхан цаг улирал байвч улцгар хоёр нүд буюу сохор нүдэнд гунигийн нулимс бөмбөрч хорвоогийн энэ сайхныг харахгүй байгаагийн гуниг зовлон бол юу идэж чадахгүй энэ модны чадалтай нэгэн адил юм хэмээсэн давхар гүн ухааны санааг энэ гуншин буюу шүлгээр гаргасан байна. Ж.Бат-Ирээдүй, Ч.Арьяасүрэн нарын зохиосон “Монгол ёс заншлын их тайлбар толь”-д төв халхад голдуу хэлэгддэг даалууны гуншинг оруулсан бөгөөд үүндээ ёозыг а, б хэмээн хоёр хувилбараар оруулсан бөгөөд а хувилбарт

Ёгзолдоржийн хөдөөнөөс

Ёнзон хамбын гадаанаас

Цайны сүүний гуйлгачин

Цалам барьсан дээрэмчин хэмээсэн байна. Энд болохоор Ёгзолдорж хэмээх хүний суудаг хөдөө нутгаас ирсэн, болсон муу юм, муу хүн, мөн Ёнзон хамбын орд өргөө, хүрээ хийд дотор халдаж чадахгүй учраас аливаа муу зүйл гаднаас нь бий болдог, гардаг бөгөөд цайны сүүний гуйлгачин бол ямар ч малгүй тарчиг хоосон болсон муу юм хийж магадгүй хийгээд цааш цалам барьсан дээрэмчин гэсэн нь энэ нь явсаар амьдрахын тулд дээрэмчин болж ч магадгүй гэсэн утгыг агуулж байгаа бөгөөд энэ нь далд утгаараа энэ мод хамгийн доод зэргийн муу мод гэдгийг гуншингаараа илтгэн харуулж байгаа хэрэг юм. Дараагийн б хувилбарт:

Хон хэрээний нүд

Хоёр нүдний дуран

Хойт хотын данжаад хэмээх гуншинг оруулсан байна.

Ёозын хоёр нүх улаан байдаг нь хон хэрээний нүдтэй төстэй харагдах бөгөөд хоёр нүдний дурантай ч адил харагдах тул дүрсээр нь ингэж нэрэлсэн болтой. Хойт хотын данжаад гэдэг нь насан өндөр болж юм үзэхээ байсан сохор шинжээр нь толгой холбон оруулжээ. Дээр дурдсан Ховд аймгийн ХИС-ийн профессор, д-р Мөнгөнхүүгийн Ганболд Ховд аймгийн Дуут сумын иргэн Урианхай ястан, 73 настай, эрэгтэй Шурагийн Сүхээс 1995оны 07 сарын 02-нд Даалууны гуншинд чансыг ташуу буюу жирүү зургаа хэмээн нэрлээд:

Хаяа голын бургас

Ханан хээтэй чанс хэмээсэн байна. Энэ нь чансыг монгол гэрийн ханатай зүйрлэн хэлсэн бөгөөд хар модтой хангайгаас бусад нутагт ихэнхдээ бургасаар хана хийдгийг Хаяа голын бургас хэмээн харуулж чанс бол хана шиг хээтэй юм хэмээн ханан хээтэй чанс хэмээн зүйрлэсэн байна. Тэгвэл мөн аймгийн Мөнххайрхан сумын нутагаас 2010 онд мөн ХИС-ийн профессор, д-р Мөнгөнхүүгийн Ганболдын бичиж авсан чансын гуншинд ташуу зургаа хэмээн нэрлээд:

Чацга сайвар чонын гүйдэл

Чанасан будаа нохойн хоол

Чацуу нэртэй зөрүү зургаа хэмээсэн нь дээрхээс огт өөр байгаа бөгөөд ядарч сульдаж зугатаж яваа яваа чоно бол чацга цувуулж хоёр хөл нь жигд биш ташуу солбин явдгийг ажигласан монгол анч, малчны ухаан бөгөөд чанасан будаа нохойн хоол гэсэн нь будаа чанаад нохойн идүүрт хийж өгөхөд нэгэн жигд тэгш харагдах байдал дүрсийг харуулан байгаа бөгөөд тийм болохоор зөрүү зургаа хэмээн нэрлэсэн байна. Тэгвэл төв халхын даалсны гуншинд чансыг:

Часаг сайвар чонын гүйдэл

Чанасан будаа нохойн хоол

Янаг хоолойн гуниг сэтгэл

Ясчин хятадын жирүү зургаа эхмээсэн байна. Эхний часаг сайвар чонын гүйдэл гэсний часаг хэмээх нь чацга хэмээсний буруу дуудсан, хэвшсэн хувилбар байж болох талтай байна. Тийм болохоор дээрх хоёр мөр нь үндсэндээ Ховд нутгийн хувилбартай ижил гэсэн үг юм. Харин янаг хоолойн гуниг сэтгэл хэмээсэн нь хайрын зовлонд унасан хүний дуу хоолой юмуу дуулах дуу дүрсээр үзүүлбэл чансны хэлбэр хэлбэр шиг зөрүү ташуу дүрсээр дүрслэгдэх талтай байж магадгүй юм. Ясчин хятадын зөрүү зургаа гэсэн нь оршуулгын ажил эрхэлдэг хүнийг ясчин гэх бөгөөд тэр хятад хүний шарил зөөдөг хайрцагны хэлбэр мөн тиймэрхүү ташуу харагддагаас ийн хэлсэн бололтой. Мөн миний өөрийн судалгаа хийж явах явцдаа Говь-Алтай аймгийн Төгрөг сумын харъяат Догмидын Санжжаваас бичиж авсан даалууны гуншинд дотроос ихэд анхаарал татсан нэгэн хувилбарыг олон зүйлийг үзэж харан судлахыг оролдлоо. Үүнд:

1. Алан тавын далан тав
 2. Аарцган махны тасархай тав
 3. Боовоо битгий барь
 4. Босоо битгий шээ
 5. Сууж шээ
 6. Сугсарч далд хий
- Эхний хоёр чүү тавын монголчилсон нэрийг баталгаажуулсан мөр байна. 3-6 мөр нь бүхэлдээ эрүүл мэндийн зөвөлгөө. Эрэгтэй хүн малчин, тариачин, дархан гээд ямар ч ажил хийж болох бөгөөд харин ажлынхаа үеэр гараа угаалгүйгээр бэлгэ эрхтэнээ барьснаас элдэв төрлийн микроп дамжиж үрэвсэхээс сэргийлсэн зөвөлгөө байна.
 - Бүр эрт үеэс л эрчүүдийг төмсгөө халуун гараараа барих буюу халуун байлгахыг хориглодог байжээ. Ялангуяа эрэгтэй хүүхдүүдийг онгорхой өмдтэй явуулдаг байсан нь нөхөн үржихүйн талын ямар нэгэн асуудалгүй хүн болоход нь чухал ач холбогдолтой байсан юм. Монголчуудын хүч чадал, эр бярын бэлгэдэл болсон хөх чоно л гэхэд ороо нь орохоос арван таван хоногийн өмнөөс мөсөн дээр төмсгөө жигнэдэгээс бэлтрэгэнүүд нь хамгийн амьдрах чадвар сайтай байдаг юм байна. Мөн сүүлийн мөрүүдэд гарч байгаа босоо битгий шээ гэснийг тайлбарлавал: уламжлал ёсоор бол монгол эрчүүд босоо шээдэггүй байжээ. Эрүүл мэндийн шинжлэх ухааны үүднээс босоо шээхэд давсаг болон түрүү булчирхайн булчингууд их хүчтэй ажилладгаас гадна давсанд шээс үлддэг байна. Харин сууж шээхэд булчингийн хүчдэл оролгүйгээр шингэн аяндаа урсан гардаг. Тиймээс түрүү булчирхайн үрэвсэл багатай байдаг байсан байна. Харин одоо босож шээдэг болсноос өвчлөл ихэсжээ. Ийм учраас л сууж шээ, сугсарч далд хий хэмээсэн эрүүл мэндийн чухал зөвөлгөө өгсөн байна. Энэтхэгийн алдарт иогч Шричинмагийн номд үүнтэй нэгэн адил зөвөлгөө байдаг бөгөөд хүний амьдралд хэрэгтэй 40 зөвөлгөөнийх нь дотор “хүнд хөнгөнөөр бие засахдаа сууж бие зас” гэсэн байдаг.

Тийм болохоор зөвхөн даалууны гурван модны гуншинг зэрвэс ажиглан шинжихэд ийм зүйл харагдаж байгаа бөгөөд эдгээр гуншинд байгаа нутаг нутгийн онцлог, ажил мэргэжлийн онцлог, ямар хүн юу эрхэлж хийдэг, ард түмний аж байдлын онцлог, тухайн нутаг орны үгийн онцлог гээд маш олон зүйлийг харж үзэж болох байна. Ийм болохоор даалууны гуншинг нарийвчлан судлах нь маш чухал юм. Д.Цэрэнсодном, Х.Сампилдэндэв нарын эмхтгэсэн *"Монгол ардын аман зохиолын дээж бичиг"*-т ШУА-ын ХЗХ-ийн эрдэм шинжилгээний ажилтнууд маш олон тооны даалууны гуншинг цуглуулсныг дурдаж нэг хэдэн хувилбарыг бараг ямар ч тайлбар судалгаагүй оруулсныг үзвэл социализмын үед мөөрийтэй тоглоомд тооцогдож хаалттай тоглоомын нэг байсан болохоор үзэл сурталын улмаас огт судлаагүй орхисон байна.

Даалууны наадгай нь хэд хэдэн төрөлтэй бөгөөд эдгээр нь өөр өөрсдийн дүрэм журамтай байдаг. Гэр барьж тоглоход хорол хэмээх монгол тоглоомын адил эрэгтэй, эмэгтэй, хүүхэд зэрэг аль ч хүн орж болдог байхад нүх шахах болон дан, давхар жаалахад голдуу эрэгтэйчүүд оролцон тоглодог байна. Ялангуяа дан, давхар жаалахад дан эрэгтэйчүүд оролцон тоглохоос гадна мөрийтэй ч бас тоглох бөгөөд дан жаалах гэдэг нь 7 халуун мод нэг талдаа нийлүүлж хожихыг, давхар нь жаран модондоо хоёр талдаа нийлүүлж хожихыг хэлдэг байна.

Монголчууд эрт цагаас үр хүүхдүүдээ ардын аман зохиолын олон төрөл зүйлээр сурган хүмүүжүүлдэг байсан. Даалуун наадгайг ажиглахад монгол ардын аман зохиолын төрөл зүйлүүдтэй адил төсөөтэй шинж чанартай байна. Тиймээс даалууны наадгай нь монгол ардын аман зохиолын нэгэн төрөл зүйл мөн билээ. Энэхүү гайхамшигт биет бус соёлын цогц өв, оюун сэтгэлгээний увидаст түлхүүрийг эдүгээчлэн баяжуулж, өнөө ба хойч үедээ өвлүүлэн үлдээх нь монгол хүн бүрийн мартаж болшгүй үүрэг мөн.

SUMMARY

Poems of the traditional Mongolian game of dominoes are one of the branches of Mongolian oral folklore. The game of dominoes came from China at the end of 19th century and developed all over Mongolia. First, it spread to towns and then to the countryside. Mongolians use its Chinese names and also gave it Mongolian names. Every name has its own poem. Those poems insert some people's names, local territory names and various pieces of advice into the game. Also, the Mongolian version replicates the special and extraordinary thinking of the Mongolian people. To properly study domino poems, we need to collect and publish them.